

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

**Оюу толгой ХХК**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин,
аюулгүй байдал, орон нутгийн хэлтэс

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1 Зорилго	4
1.2 Хэрэглээ	4
1.3 Эхлэх огноо	4
1.4 Эрх мэдэл ба удирдлага	4
2. ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ.....	5
2.2 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах нь.....	5
3. АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	5
3.1 Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага	5
3.2 Гол үялдаа холбоо	6
4. ТӨСЛИЙН СТАНДАРТ	7
4.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж ба үндэсний стандарт	7
4.2 БОНБНҮ-ний шаардлагууд	8
4.3 Монгол улсын засгийн газрын эрх бүхий байгууллагаас тогтоосон бусад үүрэг даалгавар ба шаардлагууд	8
4.4 Холбогдох олон улсын стандартууд ба удирдамжууд.....	9
4.5 Рио Тинтогийн холбогдох стандартууд	9
4.6 Төслийн холбогдох стандартуудын хураангуй	9
5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД.....	10
5.1 Хаягдлын удирдлагын ерөнхий хандлага	10
5.2 Хаягдлын удирдлагын төлөвлөгөө	10
5.3 Хэрэгжилт ба ашиглалт.....	10
5.4 Хийгдэж буй судалгаа болон моделчлох хөтөлбөр	11
5.5 Ил олборлолт болон блокчлон олборлох аргын менежмент	12
6. ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ.....	18
6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт шалгалт.....	18
7. МОНИТОРИНГ	18
7.1 Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагын тойм	18
7.2 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд.....	18
7.3 Хяналт шинжилгээний үндсэн үйл ажиллагаа	19
8. СУРГАЛТ	22

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

8.1	Тойм	22
8.2	Танилцуулах сургалт	22
8.3	Ажил үүрэгт хамааралтай сургалт.....	22
8.4	Сургалтын бусад шаардлагууд.....	22
9.	АУДИТ	22
9.1	Дотоод хяналт	22
9.2	Хөндлөнгийн аудит.....	23
9.3	Гүйцэтгэлийн тайлан.....	23
10.	БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ	23
Хүснэгтүүд		
	Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага	5
	Хүснэгт 2: Удирдлагын үндсэн хяналтууд	13
	Хүснэгт 3: Гүйцэтгэлтийн үндсэн үзүүлэлт – Эрдсийн хаягдлын удирдлага	16
	Хүснэгт 4: Хяналт шинжилгээний үндсэн хэмжүүр	18

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилго

Энэ удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- удирдлагын төлөвлөгөөний цар хүрээг тодорхойлж, бусад удирдлагын төлөвлөгөөнүүдтэй холбогдох харилцан үйлчлэлийг тогтоох;
- албан тушаалтан, түүний үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- тус удирдлагын төлөвлөгөөнд хамааралтай төслийн стандартуудыг тоймлох;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамааралтай Төслийн үүрэг амлалт, ашиглалтын журам, удирдамжуудыг тодорхойлж, тус төлөвлөгөөнд анхаарлаа хандуулж буй “Оюутолгой”-н байгаль орчны бодлогын шаардлагуудыг тусгайлан заах;
- гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтийг (ГҮҮ) тусгасан мониторинг болон тайлагналтын журмуудыг тодорхойлох;
- сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох;
- Шаардлагатай үед, тус Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилттэй хамааралтай материал, систем, үйл ажиллагааны журам ба бусад мэдээллээр хангах.

1.2 Хэрэглээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд дурдсан шаардлагыг “Оюутолгой”-н бүх үйл ажиллагаанд, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд мөрдөнө.

Тус удирдлагын төлөвлөгөөг Рио Тинтогийн 2017 оны 11-р сард гаргасан Химийн урвалд ордог эрдсийн хаягдлын менежментийн талаарх Рио Тинтогийн Байгаль орчны стандартад үндэслэн гаргасан.

1.3 Эхлэх огноо

Тус удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлнэ.

1.4 Эрх мэдэл ба удирдлага

“Оюутолгой”-н Гүйцэтгэх удирдлагын хороо тус Удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-нд баталсан.

“Оюутолгой”-н Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутаг (ЭМААБОАБОН)-ийн Ерөнхий менежер тус удирдлагын төлөвлөгөөг эзэмшинэ. Төслийн бүтэц, дүрэм журамд орсон өөрчлөлтийг тусгахаар илүү ойр ойрхон давтамжтайгаар хянан шинэчлэх шаардлагатай болоогүй л бол тус Удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам хянаж, нэмэлт өөрчлөлт, шинээр мэдээлэл оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Энэхүү Удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг Өөрчлөлтийн удирдлагын журамд заасны дагуу хянуулж, батлуулна.

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөө “Оюутолгой”-н үйл ажиллагаа, тэр дундаа гэрээт компаниудын бүх үйл ажиллагаанд хамааралтай болно.

Эрдсийн хаягдал нь хоосон чулуулаг болон хөрс хуулалтын чулуулаг, хүдрийн хаягдал ба төв дулааны цахилгаан станцын үнс зэргээс бүрдэх ба үүнийг хоосон чулуулгийн овоолгод (ХЧО) хүчил үл үүсгэх хаягдал байдлаар хаяж, тэдгээрийг тус овоолго дээр капсул болгон хаалтын үйл ажиллагааны дараа газрын гадаргуугаас тусгаарлах юм.

Тус удирдлагын төлөвлөгөөнд лицензийн талбайн гадна ба дотор явагдаж буй үндсэн ба гэрээт компаниудын бүх үйл ажиллагааг хамруулсан. Гэрээт гүйцэтгэгчдийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг гэрээт гүйцэтгэгчдийн удирдлагын хүрээнд тусгасан (ОТ-07-PLN-9001).

2.2 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах нь

Энэ удирдлагын төлөвлөгөө нь “Оюутолгой”-н Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНМТ)-ний ерөнхий бүтцэд тодорхойлогдсон төслийн Ашиглалтын үйл ажиллагааны удирдлагын багц төлөвлөгөөний нэг хэсэг юм. (ОТ-10-PLN-0003).

Тус удирдлагын төлөвлөгөө нь дараах хэд хэдэн удирдлагын төлөвлөгөөтэй давхцадаг:

- Гадаргын болон гүний усны эх үүсвэрийг ослын хэмжээнд бохирдуулах үед хэрэгжүүлэх Онцгой байдлын арга хэмжээний төлөвлөгөө (ОТ-12-PLN-0011), мөн хаягдал хадгалах байгууламжийн онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө;
- Хөрсний удирдлага болон эвдэрсэн газрын нөхөн сэргээлттэй холбоотой Газар хөндөхөд тавих хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0005) ;
- Усны эх үүсвэрийн удирдлагын төлөвлөгөөтэй (ОТ-10-Е11-PLN-0001) Хоосон чулуулгийн овоолго (ХЧО) болон Хаягдал хадгалах байгууламжийн (ХХБ) усны эх үүсвэрт үзүүлж болзошгүй нөлөөлөлтэй холбоотойгоор;
- Уурхайн хаалтын төлөвлөгөөтэй (ОТ-10-Е9-PLN-0002) Хаягдал хадгалах байгууламж болон Хоосон чулуулгийн овоолгын нөхөн сэргээлттэй холбоотойгоор тус тус давхцадаг.

3. АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлагыг доор тоймлон харуулав.

Хүснэгт 1: Гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага

Албан тушаал	Үүрэг хариуцлага
---------------------	-------------------------

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-ПЛН-0001-Е	Хувилбар: 1.4

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутгийн ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> • Эрдсийн хаягдлын мониторинг, нөлөөлөл бууруулах арга хэмжээ, судалгаа, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангах.
Байгаль орчны менежер	<ul style="list-style-type: none"> • Жилийн Байгаль орчны удирдлагын орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх. • Жилийн турш эрдсийн хаягдлын хувьд гаргасан аливаа ололт амжилтыг тодорхойлсон жилийн байгаль орчны тайланг боловсруулах. • Хэлтсийн менежерүүд болон гол гэрээт гүйцэтгэгчдэд Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх.
Ус, хаягдлын багийн ахлагч	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны хяналт шинжилгээний жилийн төлөвлөгөөний Эрдсийн хаягдлын тухай хэсгийг боловсруулах. • Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд өгөх байгаль орчны жилийн тайлангийн судалгаа, мониторинг, нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг тусгасан эрдсийн хаягдлын тухай хэсгийг боловсруулах. • ОТ-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац болон овоолгын удирдлагын нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.
Ил болон далд уурхайн хэлтсүүд болон гол гэрээт гүйцэтгэгчдийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааг энэ удирдлагын төлөвлөгөөний дагуу явуулах. • Эрдсийн хаягдлын үйл ажиллагааг мэргэшсэн боловсон хүчнээр хийлгэх. • Бүх осол, зөрчлүүдийг тайлагнаж, тэдгээрт зохих ёсоор магадлан шинжилгээ хийх. • ОТ-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац болон овоолгын удирдлагын нэгдсэн төлөвлөгөөний үйл ажиллагааны талын асуудлыг хэрэгжүүлэх.
Ажлын байрны ахлах ажилтнууд/ахлах мэргэжилтнүүд	<ul style="list-style-type: none"> • Энэ удирдлагын төлөвлөгөөний шаардлагад хамааралтай үйл ажиллагааны нийцтэй байдлын мониторинг хийхийн тулд ажлын байрны үзлэг шалгалт зохион байгуулах. • Эрдсийн хаягдлын бүх мэдээллийг бүртгэж, тайлагнах.
Нийт ажилчид ба гэрээт гүйцэтгэгчид	<ul style="list-style-type: none"> • Эрдсийн хаягдлын байгаль орчинд нөлөөлөл үзүүлэхэд хүргэх үйл ажиллагаа бүрийг тайлагнах. • Тус удирдлагын төлөвлөгөөг зөрчиж буй бүх үйл ажиллагааг тайлагнах.

3.2 Гол уялдаа холбоо

Энэ удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх харилцагчид (энэ удирдлагын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд үүрэгтэй албан тушаалтан г.м.) нь:

- Ил болон далд уурхайн хэлтэс, ялангуяа газар болон усны эх үүсвэрийг Хоосон чулуулгийн хүчиллэг урсац ба хүчил үүсгэж болзошгүй (ХҮБ) хаягдал материалуудаас хамгаалж, Хоосон чулуулгийн овоолго нь энэ төлөвлөгөө ба холбогдох баримт бичгийн дагуу баригдаж, ашиглагдан, хаагдаж буйг нягтлах;
- Уурхайн техникийн үйлчилгээний хэлтэс, ялангуяа уурхайн эрдсийн хаягдал хаях цэгийн тогтвортой байдал болон хаягдал хадгалах байгууламж дээр гүний усны эх үүсвэрийг хамгаалах асуудалтай холбоотойгоор;

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-ПЛН-0001-Е	Хувилбар: 1.4

4. ТӨСЛИЙН СТАНДАРТ

“Оюу толгой”-н бүх үйл ажиллагаа холбогдох стандарт (төслийн стандарт)-уудад нийцсэн байх шаардлагатай. “Оюу толгой”-н стандартуудад:

- Монгол Улсын Үндэсний холбогдох стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлагууд;
- Монгол Улсын Засгийн газрын агентлагуудаас тавьсан шаардлагууд ба бусад үүрэг амлалтууд;
- Зээлдүүлэгчийн холбогдох стандартууд ба удирдамжууд;
- Рио Тинтогийн холбогдох стандартууд;
- Оюутолгой дагаж мөрдөх үүрэг хүлээсэн аж үйлдвэрийн бусад удирдамжууд орно.

4.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж ба үндэсний стандарт

Монгол Улсын стандартууд ба журмууд

Монгол улсын байгаль орчны тухай дараах хуулиуд эрдсийн хаягдлын удирдлагад хамааралтай:

- 1988 онд батлагдаж 2005 онд нэмэлт өөрчлөлт хийгдсэн Газрын хэвлийн тухай хууль нь эдийн засгийн ач холбогдолтой эрдэс материалууд болон уул уурхайн бус үйл ажиллагаа гэсэн газрын хэвлийн материалуудын ашиглалтыг зохицуулж, олборлолтын үеийн газрын хэвлийн ашиглалтад тавих шаардлагуудыг тодорхойлдог.
- 1994 онд батлагдаж, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Газрын тухай хууль нь төрийн өмчийн газрын эзэмшил, ашиглалт болон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах ба эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх гэх мэт холбогдох бусад асуудлуудыг зохицуулдаг. Газарт мониторинг хийж, хамгаалж, нөхөн сэргээж, зөвшөөрлийн дагуу ашиглах ёстой. Хүний эрүүл мэнд, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал болон үндэсний аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болох аливаа үйл ажиллагааг хориглодог. Гадаад улс орон, олон улсын байгууллагууд, хуулийн этгээд болон иргэд нь газрыг тусгай зориулалтаар, тодорхой хугацаанд гэрээний нөхцөлийн дагуу хуульд нийцүүлэн ашиглах боломжтой.
- 2012 онд шинэчлэгдэн найруулагдаж, батлагдсан Агаарын тухай хууль нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, өнөө болон ирээдүй үедээ байгалийн тэнцвэрийг хадгалан үлдээхийн тулд агаарын хамгаалалт болон агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулдаг. Тус хуулиар агаарын бохирдлын суурин эх үүсвэрүүдэд гэрчилгээжилтийн систем тогтоож, агаарын бохирдлын түвшингээс нь хамааруулан төлбөр ноогдуулсан. Гэрчилгээг орон нутгийн засаг даргаас авах шаардлагатай.
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиар (Тус хууль 2010 оны 6 сарын 24-нд хүчин төгөлдөр болсон ба 2012 оны 6 сарын 23-нд нэмэлт өөрчлөлт оруулсан) агаарын бохирдлын төлбөр ногдуулж, төлбөрийн хэмжээг тогтоосон. Хийн хаягдлын мониторинг ба хүлэмжийн хийг бууруулах технологи г.м. агаарын бохирдлыг бууруулах технологийг шинэ буюу өргөтгөсөн бүх байгууламжуудад олон улсын стандартын дагуу хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн тус хуулиар агаар мандалд ялгарсан хийн хаягдлын төлбөрийн системийг тогтоосон. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль эдгээр төлбөрүүдийг дэлгэрэнгүй тодорхойлсон.

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

- 2012 онд шинэчлэн найруулж баталсан Усны тухай хууль нь усны хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлт болон усны сав газруудтай холбоотой асуудлуудыг зохицуулдаг. Тус хуулиар усны эх үүсвэрийн бүртгэлийн журам болон Монгол Улсын засаг захиргааны бүх түвшний удирдлагуудад усны асуудлаар өгөгдсөн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг тодорхойлж, хуулийн этгээд бохир усыг дахин ашиглахыг дэмжсэн. Үйлдвэрлэлийн ажиллагааны явцад бохир ус үйлдвэрлэж байгаа ус хэрэглэгч буюу этгээд ус бохирдуулсны төлбөрийг төлөх шаардлагатай. 2012 онд баталсан Усны бохирдлын тухай хуулинд заасан журмын дагуу усны бохирдлын төлбөрийг тогтоож, авна. Төлбөрийн хэмжээ килограмм тутамд 100 – 500 төгрөг байна.
- 2012 онд шинэчлэн найруулж, батлан 2012 оны 6 сарын 23-нд хүчин төгөлдөр болсон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүдэд чиглэсэн байдаг. Тус хуулийн дагуу лиценз эзэмшигч хоосон чулуулгийн удирдлагын журмыг багтаасан байгаль орчныг хамгаалах болон удирдлагын төлөвлөгөөнүүдтэй байх ёстой.
- 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хууль нь хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, хадгалалт, дахин ашиглалт, устгалын асуудлыг зохицуулдаг. Энэ хуулиар лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах болон хоосон чулуулгийн журмыг агуулсан удирдлагын төлөвлөгөөтэй байх ёстой.
- Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмүүд (Үйлдвэр, худалдааны яамны сайдын 2003 оны 98 дугаар захирамжаар батлагдсан). Эдгээр аюулгүй ажиллагааны дүрмүүд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашигт малтмалын ордыг ил уурхайн аргаар олборлодог уул уурхайн компаниудын хоосон чулуулаг ба ус зайлуулалтын үйл ажиллагааны журмуудыг тусгасан.

Монгол Улсын дараах стандарт, журмууд нь эрдсийн хаягдлын удирдлагын шаардлагуудыг багтаасан байдаг:

- MNS 4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус;
- MNS 4916:2000 Байгаль орчин. Алтны шороон ордыг ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт;
- *MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйл ажиллагаагаар хөндсөн газрын хөрсийг сайжруулах нь. Техникийн ерөнхий шаардлагууд.*
- MNS 3342:1982 Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлагууд;

4.2 БОНБНУ-ний шаардлагууд

БОНБНУ-нд хавсаргадаг Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхойлогдсон эрдсийн хаягдал чулуулгийн удирдлага ба мониторингийн шаардлагуудыг тус удирдлагын төлөвлөгөөнд оруулсан.

4.3 Монгол улсын засгийн газрын эрх бүхий байгууллагаас тогтоосон бусад үүрэг даалгавар ба шаардлагууд

Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг даалгаврыг тодорхойлсон гол баримт бичиг нь 2009 оны 10 сарын 6-ны өдөр хийгдсэн Төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ юм. Зургадугаар бүлэг (Байгаль орчин) нь эрдсийн хаягдлын удирдлагад шууд хамааралтай биш боловч (6.4, 6.9, 6.10) заалтууд дараах шаардлагуудыг тодорхойлсон байдаг:

- Хөрөнгө оруулагч нь Төслийн хэрэгжилттэй холбоотой Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /цаашид “БОХТ” гэх/, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах жил

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

бүрийн бүх зардлыг хариуцах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд дурдсан арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаа тухай хараат бус, мэргэшсэн, эрх бүхий хөндлөнгийн шинжээчийн тайланг 3 /гурав/ жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

- Хөрөнгө оруулагч нь Үндсэн үйл ажиллагаатайгаа холбоотой байгаль орчны хяналт шинжилгээ, үнэлгээний иж бүрэн хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа материаллаг сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол Хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

4.4 Холбогдох олон улсын стандартууд ба удирдамжууд

“Оюутолгой” төслийн хэрэгжүүлэх олон улсын стандартууд нь Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) ба Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) тавьдаг дараах стандартууд юм:

- ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий удирдамжууд (2007 оны 4-р сар);
- ОУСК-ийн уул уурхайд тавих Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамжууд (2007 оны 12-р сар);
- ОУСК-ийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандартууд (2006 он) (тухайлбал ГС1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба удирдлагын системүүд ба ГС3 Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба бууруулах);
- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагууд (2008 он) (ялангуяа ГШ1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба удирдлага болон ГШ3: Бохирдлоос урьдчилан сэргийлэх ба бууруулах).

Түүнчлэн энэхүү удирдлагын төлөвлөгөө нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараах тэргүүлэх туршлагуудыг харгалзан үзсэн:

- Олборлох аж үйлдвэрийн хаягдлын удирдлагын тухай ЕХ-ны 2006/21/ЕЕС удирдамж;
- Уурхайн үйл ажиллагааны хаягдал хүдэр ба чулуулгийн удирдлагын тэргүүлэх туршлагын тухай ЕХ-ны лавлагаа баримт бичиг (2009 оны 1-р сар)

4.5 Рио Тинтогийн холбогдох стандартууд

Эрдсийн хаягдлын удирдлагад хамааралтай Рио Тинтогийн гол стандарт нь Байгаль орчны стандарт - Химийн урвалд ордог эрдсийн хаягдлын удирдлага (2017 оны) юм.

4.6 Төслийн холбогдох стандартуудын хураангуй

“Оюутолгой” төсөл нь үндэсний стандарт, зээлдүүлэгчдийн стандарт, Рио Тинтогийн стандартуудаас хамгийн хатууг нь төслийн стандарт болгон тухайн стандартад нийцэж ажиллах болно. Эрдсийн хаягдлын стандартын хувьд, тус удирдлагын төлөвлөгөө амжилттай хэрэгжиж байгаа эсэхийг усны чанарын стандартууд ([Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө](#)г харна уу, ОТ-10-Е11-PLN-0001) болон

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

тоосжилттой холбоотой (Агаар мандалд ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөөг харна уу, ОТ-10-Е12-PLN-0001) агаарт ялгарах хийн хаягдлын стандартуудын гүйцэтгэлээр хэмжинэ.

5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД

5.1 Хаягдлын удирдлагын ерөнхий хандлага

Тус удирдлагын төлөвлөгөөний гол зорилго нь шинээр үүсэх хаягдлыг аюулгүй тээвэрлэж, боловсруулж, зайлуулахын тулд “Оюутолгой”-н эрдсийн хаягдал болон баяжуулах үйлдвэрийн хаягдлын удирдлагын зохистой хэрэгжилтийг баталгаажуулах явдал юм. Үүнийг баталгаажуулахдаа эрдсийн хаягдлын байгууламж болон талбай нь физик, биологи, химийн хувьд аюулгүй найдвартай гэдгийг магадална. Эрдсийн хаягдлын гарц, үүнээс болж эвдрэх газрын хэмжээг багасгаж, хаягдлыг дахин ашиглах, уурхайн талбайд буцааж булах болон техник-эдийн засгийн хувьд үр ашигтайгаар нөхөн сэргээх боломжуудыг хайдаг.

Үүнд шимт хөрс, тунамал элс, хайргыг бусад барилгын ажил, талбайн нөхөн сэргээлтэд ашиглах зэрэг эрдсийн хаягдлын дахин ашиглалтыг багтаасан. Хүчил үүсгэгч ба хүчил үл үүсгэгч хоосон чулуулгийг ХХБ-ийн далангийн барилгын ажилд өргөнөөр ашиглах ба хүчил үл үүсгэгч болон хүчил саармагжуулагч материалыг уурхайн олборлолтын дараах газар хэлбэржүүлэлтэд хучих материал, тогтворжуулагч, хүчил саармагжуулагч болгон ашиглана.

Үе шаттай нөхөн сэргээлт, уурхайн талбайн хучилт, ялангуяа Хоосон чулуулгийн овоолго зэргийн гадаргууг аюулгүй, тогтвортойгоор хэлбэржүүлэхийн тулд тэдгээрийг тухайн нутгийн эргэн тойрны газрын гадаргын төрхтэй ижил толгод мэт хэлбэртэйгээр хэлбэржүүлнэ.

5.2 Хаягдлын удирдлагын төлөвлөгөө

Ашигт малтмалын орд газрын хэсэг бүрийн олборлолт, ашиглалтаас үүсэх хаягдлын хэмжээ, физик ба химийн шинж чанар, аюулыг тодорхойлж, үнэлэх, баримтжуулахын тулд “Оюутолгой” компани эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөлтийг хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөөг “Оюутолгой”-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын хэрэгжилтийн цогц төлөвлөгөөний дагуу боловсруулах ба тус төлөвлөгөөг боловсруулснаар “Оюутолгой” өөрийн эрдсийн хаягдлын бүртгэлийг хянаж, хаягдлын урт хугацааны физик, химийн шинж чанар болон байгаль орчны нөлөөллийн өнөөгийн загварчлалыг хийх боломжтой болох юм. Эдгээрийг туршилт ба мониторингийн мэдээг ашиглан шалгах боломжтой.

“Оюутолгой”-н Эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын цогц төлөвлөгөө дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Хаягдал ба хаягдлын байгууламжийн физик, химийн аюулын үнэлгээний хураангуй;
- Хими болон физик аюулуудыг бууруулах арга хэмжээнүүд;
- Эрдсийн хаягдлын удирдлага ба талбайн өнөөгийн нөхцөлд удирдлагын төлөвлөгөөг өдөр тутам хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой үүрэг, хариуцлагуудын хуваарилалт;
- Хэрэгжиж буй нарийвчилсан мониторинг ба мэдээлэл цуглуулах шаардлагууд;
- Онцгой байдлын төлөвлөгөө ба хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгдөөгүй нөхцөл, гэнэтийн нөлөөллийн үед авах арга хэмжээнүүд.

5.3 Хэрэгжилт ба ашиглалт

Энэ эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө нь “Оюутолгой”-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын цогц төлөвлөгөөний дагуу хэрэгжинэ.

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

Түүнчлэн хоосон чулуулгийн зохих ёсоор ангилан ялгах, тээвэрлэх, хадгалах, удирдахтай холбоотойгоор “Оюутолгой”-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын цогц төлөвлөгөө нь дараах журмуудаар улам баяждаг. Эдгээр нь Оюу толгойн эрдсийн хаягдлын удирдлагын үйл ажиллагаануудын талаар илүү дэлгэрэнгүй харуулсан байдаг. Үүнд:

- Өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх, хадгалахтай холбоотой асуудлыг зохицуулсан Өнгөн хөрстэй ажиллах журам (ОТ-10-Е14-PCR-0001),
- Хаягдлын сангийн хаягдал материалыг удирдахтай холбоотой асуудлыг зохицуулсан Хаягдал хадгалах байгууламжийн төслийн гүйцэтгэл, удирдлагын төлөвлөгөө ;;
- Усны мониторингийн төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0002).

Түүнчлэн, дараах журам нь Рио Тинтогийн Химийн урвалд ордог эрдсийн хаягдлын удирдлагын стандартын хэрэгжилтийг дэмждэг:

- “Оюу толгой”-н ЭМААБООАБОН-ийн МС-ийн 3–р элемент, Эрсдэлийн бүртгэлийн бэлтгэл ажил (ОТ-03-PRC-0001-Е Аюул ба эрсдэлийн удирдлага).

Дараах хүснэгтэд энэ Удирдлагын төлөвлөгөөний хэсэг болгон “Оюу толгой”-н хийж гүйцэтгэх гол удирдлагын хяналт ажлуудыг харуулав.

5.4 ХИЙГДЭЖ БУЙ СУДАЛГАА БОЛОН ЗАГВАРЧЛАХ ХӨТӨЛБӨР

Геохимийн томоохон багц өгөгдөл бэлэн байгаа бөгөөд олборлолт явагдах хугацаанд тасралтгүй шинэчлэх шаардлагатай.

- **Хаягдал чулуулаг ба хүдэр**

Бүх өрмийн цооногийн дээжүүдэд тогтмол аналитик давхаргасын нэг хэсэг болох Лесо нийт хүхэр болон нийт нүүрстөрөгч багтана. Эдгээр өгөгдөл нь хаягдал чулуулгийг Хүчил үл үүсгэгч/Хүчил үүсгэх чадвартай болгон ангилах, хаягдлын химийн шинж чанарын тооцоог боловсронгуй болгох, хаалтын үед ил уурхай болон блокчлох олборлолтын үеийн усны химийн шинж чанарыг тооцоход ашиглах хүхрийн блок загварчлалыг боловсронгуй болгоход ашиглагдана.

Уурхайн талбай дахь лабораторид сонгосон тэсэлгээний цооногоос авсан дээжид нийт хүхэр болон нийт нүүрстөрөгч байгаа эсэхийг шинжилж Хүчил үл үүсгэгч/Хүчил үүсгэх чадвартай ангилал хийх бодит хугацааны өгөгдлийг гаргах, блок загварчлалыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх болон блок загварчлалд ЧБ/ЧХ шалгалтыг явуулах хэрэгтэй.

Шинжилгээний аргачлалд хүчил шүлтийн тооцоолол (нийт хүхэр, нийт нүүрстөрөгч болон хүчил саармагжуулах чадавхи) ба бүх дээжид хийх нэг удаагийн нийт хүчил тодорхойлох (NAG)-ын шинжилгээ, үүний дараа дээжийн дэд олонлогт нэмэлт илүү нарийвчилсан шинжилгээг багтаах ёстой.

- **Хаягдал**

Улирал тутам төлөөлөл болох нийт хаягдлаас дээж авч бүрэн хүчил шүлтийн тооцоолол болон нийт хүчил тодорхойлох шинжилгээг хийнэ. Баяжуулах үйлдвэрээс нийлмэл дээж авахад, нийт улиралд төлөөлөл болгон авсан дээжийг ашиглахад илүү тохиромжтой байна. Хэрэв нийлмэл дээж авах боломжгүй байвал шинжилгээ хийхийн тулд сар тутам санамсаргүй сонголтоор нийлмэл эсхүл граб дээж авах шаардлагатай. Үйлдвэрлэлийн хугацаанд хаягдлын дээжээр төлөөлүүлэх хүдрийн тэжээлийн шинж чанарын тухай мэдээллийг мөн нэгтгэнэ. Анхдагч өгөгдөл нь дор хаяж нийт хүхэр, нийт метал (ялангуяа Си) болон хүдрийн тэжээлд хувь нэмэр оруулж буй давхарга багтаах ёстой.

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-ПЛН-0001-Е	Хувилбар: 1.4

5.5 ИЛ ОЛБОРЛОЛТ БОЛОН БЛОКЧЛОН ОЛБОРЛОХ АРГЫН МЕНЕЖМЕНТ

Оюу хүдрийн биетүүд рүү ил олборлолтын аргаар нэвтрэх бөгөөд Хюго хүдрийн биетүүдийг блокчлон олборлох аргаар олборлоно. ХҮЧИЛ ҮҮСГЭХ ЧАДВАРТАЙ чулуулгийг ил уурхайн хажууд ил гарах бөгөөд блокчлон олборлох хайрганы бүсэд байна гэж таамаглаж байгаа. Ил уурхайн ёроол болон далд малталтын үеэр цуглах шүргэлцэх ус нь рН бага, давсжилт ихтэй, металлын концентраци нь хүрээлэн буй орчин руу гаргахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс их байна. Ил олборлолт буюу далд малталтаас соруулсан усыг боловсруулах усны эргэлт рүү нийлүүлнэ. Хэрэв ус хүчиллэг бол үүнийг илүү их эзлэхүүнтэй боловсруулах усны эргэлтэд оруулж хурдан саармагжуулна. Саармагжуулах явцад үүссэн аливаа тунадасжилтыг илүү их хаягдлын масс руу хаяна. Ил уурхайн болон далд малталтыг чиглэсэн цацраган гүний усны урсгалыг бүхий ажиллагааны туршид хадгалж орчны гүний усыг бохирдуулах эрсдэлийг бага хэмжээнд байлгана.

Хаалтын үеэр жижиг цаг зуурын эсхүл урт хугацааны нуур ил уурхайн ёроолд үүсэж магадгүй байна. Ууршилт нь хур тунадастай харьцуулахад хамаагүй их байдаг учраас нуур нь олборлолтын өмнөх гүний усны түвшинд хүрч нөхөн сэргээгдэхгүй бөгөөд салаалсан гүний усны урсгалын нөхцөл тогтмол хэвээр байх ёстой. Ил уурхайгаас ямар нэг гадаргын буюу гүний усны гарш гарахгүй учраас доош налсан усны нөөцөд учрах эрсдэл бага байна. Хаягдал чулуулгийн овоолго болон ХАБ-уудаас гарах хүрэлцэх усыг урт хугацааны усны менежментийн стратегийн нэг хэсэг болгон ил уурхай руу ууршуулахаар чиглүүлнэ.

Блокчлон олборлох газарт эсвэл эргэн тойронд нь байгаа усыг нь шавхсан уурхайн цул нь хаалтын дараа аажмаар усанд автана. Дахин усанд автуулах үед газрын доорх усны шууд урсцыг далд уурхай, ан цав бүхий чулуулгийн цулд чиглүүлсэн хэвээр байна. Гэхдээ үүний үр дүнд, гүний усны түвшин олборлолт эхлэхээс өмнөх үетэй ижил түвшинд хүрч нөхөн сэргэх бөгөөд тасралтгүй урсгал дахин үүсэж болно. Энэхүү нөхцөл байдал үүссэн үед блокчлон олборлох хэсгээс бохирдсон ус шууд утгаараа гарч эхэлнэ. Гэхдээ, блокчлон олборлох газрын сууриас ямар нэг гадаргын усны гарш байх ёсгүй. Эрдэсжсэн үлдэгдэл чулуулгийн цул усанд автахад, хүчил төрөгчийн нэвчилтийг хянаж сульфидын исэлдлийг огцом бууруулна. Блокчлон олборлолт нь усанд автсаны дараа ХЧУ-ын үргэлжилсэн эх сурвалж байхгүй. Гэхдээ, блокчлон олборлолт болон хайрганы бүс дэх усны химийн шинж чанарыг хаалтыг төлөвлөх үйл явцын нэг хэсэг болгон тооцно. Хэрэв шаардлагатай бол, блокчлон олборлолтын хаалтын дараах усны чанарыг хамгийн хүчтэй хүчил ялгаруулах материалыг хурдан усанд автуулах буюу усаар дүүргэх үед нэмэлт шүлтлэг хийх замаар сайжруулж болно. Газар доорх усыг блокчлон олборлох хэсгээс ил уурхайн гүн рүү чиглүүлж, ууршуулах, далд уурхайн хэсэг рүү шууд урсгах зорилгоор гидрогеологи ил уурхайн холбоог үүсгэж болно.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

Хүснэгт 2. Удирдлагын гол хяналтууд

ID	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Хяналтын хэлбэр
MW01	Шимт хөрсний үлдэгдэл ба ангилал	Газрыг барилга (Хоосон чулуулгийн овоолго, агуулах, хаягдал хадгалах байгууламж болон бусад дэд бүтэц) болон уурхайн зориулалтаар хөндөхөөс өмнө шимт хөрс, тунамал элс, хайргыг хуулан авч зөвшөөрөгдсөн хадгалах байршил руу тээвэрлэнэ. Тус үйл ажиллагааг Газар хөндөхөд тавих хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.	ЭМААБОАБОН-ийн хэлтэс –Байгаль орчны баг Ашиглалтын хэлтсүүд	Дотоод аудитын хөтөлбөр Газар хөндөх зөвшөөрөл
MW02	Ундай голын голдирол өөрчлөлт	Ундай голын голдирлыг өөрчлөх далангийн ажлыг дуустал Ундай голын сувагт хаягдал чулуулаг байрлуулахгүй.	Ил уурхайн хэлтэс	Хийж дууссан-Хянах шаардлагагүй
MW03	Ундай голын голдирол өөрчлөлт	Өмнөд хаягдлын чулуулгийн овоолгын урд хэсэгт (доошоо налуу) Ундай голын идэвхигүй сувгийг хөндөлдүүлж үл нэвчих цөөрөм барих шаардлагатай. Тус цөөрөмд хаягдлын чулуулгийн овоолгоос шүүрэлт, урсац, хүлээж авах цуглуулах гол өгссөн цуглуулах цөөрөм багтах бөгөөд цуглуулсан аливаа усыг нэг бол ууршуулна эсвэл Усны хяналт шинжилгээний төлөвлөгөөний дагуу зохицуулна.	Барилгын хэлтэс	Хийж дууссан-Хянах шаардлагагүй
MW04	Эрдсийн хаягдлын ангилал	Хоосон чулуулаг, хөрс хуулалтын нягтраагүй чулуулаг, бага агуулгатай хүдэр зэргийг зэс, нийт хүхрийн агуулга болон эрдсийн найрлага дээр нь үндэслэн “Оюутолгой”-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын цогц төлөвлөгөөний дагуу ангилна.	Ил уурхайн хэлтсийн Ил уурхайн техникийн үйлчилгээний баг Гүний уурхайн хэлтсийн Гүний уурхайн техникийн үйлчилгээний баг	Дотоод аудитын хөтөлбөр

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

ID	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Хяналтын хэлбэр
MW05	Эрдсийн хаягдал чулуулгийн ангилалт	1-р босоо амны үйл ажиллагааны чулуулгийн овоолго дах бүх чулуулгийг хүчил үүсгэж болзошгүй чулуулагт тооцдог. Ил уурхайн хүчил үүсгэж болзошгүй хаягдал чулуулгийн овоолго эсхүл ХХБ-ийн барилгын ажлын хүчил үүсгэж болзошгүй чулуулгийн бүс руу эцэслэн шилжүүлэн зөөх хүртэл 1-р босоо амны чулуулгийн овоолгыг ХҮБЧ-ийн овоолго хэмээн удирдан зохицуулна.	Гүний уурхайн хэлтсийн Гүний уурхайн техникийн үйлчилгээний баг	Геотехникийн үзлэг шалгалт
MW06	Эрдсийн хаягдлын ангилан ялгалт	Бүх хүчил үл үүсгэгч болон ХҮБЧ-ийн стандартын дагуу хянан, зохицуулдаг далд уурхайн хаягдал чулуулгийн нэгдсэн (бүх босоо ам, налуу малталтад үйлчилнэ) овоолгод ХҮБЧ-ийг байрлуулна. Хүчил үл үүсгэгч чулуулгийг барилгын ажил/хаалтын материалд ахин ашиглахаар түр овоолгод байрлуулна, эсвэл далд уурхайн хаягдал чулуулгийн нэгдсэн овоолгод байрлуулна .	Гүний уурхайн хэлтэс Уурхайн техникийн үйлчилгээний баг	Эрдсийн хаягдлын бүртгэл Дахин ашигласан хүчил үл үүсгэгч чулуулаг бүрийн геологи болон хүхрийн туршилтын хариу
MW07	Ангилалдсан исэлдсэн материал	Ангилалдсан исэлдсэн материал (SOM)-ыг ангилалдсан ислийн материалын салангид овоолгод тусад нь овоолох ба уусгах буюу дуусах хүртэл хүчил үүсгэх боломжтой чулуулаг хэлбэрээр боловсруулж, зохицуулдаг.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Эрдсийн хаягдлын бүртгэл Геохимийн шинжилгээ
MW8	Дулааны Төв станцын үнс	Дулааны төв станцаас гарах үнсийг хүчил үүсгэгч чулуулаг хэлбэрээр боловсруулж, Хоосон чулуулгийн овоолго дээр капсул хэлбэрт оруулна.	Дэд бүтцийн хэлтсийн Дулааны төв станц	Эрдсийн хаягдал чулуулгийн бүртгэл

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

ID	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Хяналтын хэлбэр
MW09	Хүчиллэг чулуулгийн урсац	Хоосон чулуулгийн овоолгууд болон бусад овоолгуудын хүчиллэг чулуулгийг урсцын хяналтын стратеги дараах хэсгээс бүрдэнэ: 1) Хүчил үл үүсгэх ба үүсгэх боломжтой чулуулгийг ангилан тусад нь боловсруулах; 2) Үйл ажиллагааны талбайн хэмжээнд хүчил үүсгэх чулуулагтай урвалд орсон усыг барьж хязгаарлах бодлого; ба 3) Хүчил үүсгэх боломжтой хаягдал чулуулгийн гадаргууг хучсаны дараа хүчил үл үүсгэх хаягдал чулуулгаар бүрж, хадгалалтын бүрхүүлийн системийг байгуулна.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг Гүний уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Эрдсийн хаягдлын бүртгэл Геохимийн шинжилгээ
MW10	Хоосон чулуулгийн гадаргын хэлбэржилт	Хоосон чулуулгийн овоолго, бага агуулгатай хүдрийн овоолго, ангилагдсан исэлдсэн материалын овоолгуудыг харагдах үзэмжид сөргөөр нөлөөлөхөөргүйгээр газрын дундаж гадаргаас дээш 90 м-с дээш гарахгүй өндөртэй байлгах шаардлагатай ба мөргөцөг бүрийн өндөр 30 метрээс хэтрэх ёсгүй.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Тогтмол хэмжилт судалгаа
MW11	Хоосон чулуулгийн гадаргын хэлбэржилт	Улнаас тааз хүрэх нийт налууг 22°-с хэтрүүлэхгүйн тулд хоосон чулуулгийн овоолго, бага агуулгатай хүдрийн овоолго ба ангилагдсан исэлдсэн материалын овоолго зэрэг нь шаталсан хэлбэртэй байх ёстой (2.5:1 хөндлөн:босоо) ба дахин хэлбэржүүлсний дараа налуугийн аль ч хэрчим 26°-с (2:1) хэтрэх ёсгүй.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Тогтмол хэмжилт судалгаа
MW12	Хоосон чулуулгийн овоолгын хаалтын үйл ажиллагаа	Хаалт болон ашиглалтын үед гадаргын усны чанарыг хамгаалах, шүүрэлтийг бууруулах, салхины элэгдлийг хянах болон ургамалжуулах зорилгоор хүчил үүсгэх боломжтой бүх чулуулгийг хүчил үл үүсгэгч чулуулгаар хучна.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Нөхөн сэргээлтийн бүртгэл тэмдэглэл

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

ID	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Хяналтын хэлбэр
MW13	Хоосон чулуулгийн овоолгын Удирдлага	Байгаль орчин болон геотехникийн илэрхий эрсдэл байгаа эсэхийг нягтлахын тулд хоосон чулуулгийн овоолгын геотехникийн болон геохимийн шинж чанарыг ашиглалт, хаалтын үе шатны турш зохицуулж, хянаж шинжилнэ. Асуудалтай газар бүрт засаж залруулах зохих арга хэмжээ авч, сөрөг нөлөөллийг бууруулна.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг Гүний уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Геотехникийн үзлэг шалгалт Геотехникийн үнэлгээ (ХХБ) Хоосон чулуулгийн данс бүртгэл
MW14	Хаягдал хадгалах байгууламжийн удирдлага	Хаягдал хадгалах байгууламжийг “Оюутолгой”-н Хаягдал хадгалах байгууламжийн төслийн гүйцэтгэл, удирдлагын төлөвлөгөө”-нд тодорхойлсон зураг төслийн шалгуурыг хангахуйц түвшинд барина. Хүчиллэг чулуулгийн урсац үүсгэхгүйн тулд хаягдлын нэвчилтийн усыг хүчил үүсгэж болзошгүй чулуулагтай нийлэх байдлыг бууруулахын тулд ХХБ-ийн далангийн зураг төслийг гаргаж байгуулсан.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Жил тутмын зураг төслийн тайлан Барилгын чанарын баталгаа ба хяналтын төлөвлөгөө
MW15	Хаягдал хадгалах байгууламжийн удирдлага	Барилга угсралт, ашиглалтын үе шатанд хажуугийн хэсэг нь хүлээн зөвшөөрөгдөхгүй хэмжээгээр хазайж шилжсэн, суулт өгсөн болон элэгдсэн эсэхийг хянахын тулд хаягдал хадгалах байгууламжийн далан, хоосон чулуулгийн овоолго ба бусад овоолгуудын ажиглалтыг өдөр тутам хийнэ.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг Гүний уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Геотехникийн үзлэг шалгалт
MW16	Хаягдал хадгалах байгууламжийн хаалтын үйл ажиллагаа	Хаягдлын сүүлчийн үе давхаргыг хийсний дараа гадаргууг хүчил үл үүсгэгч хоосон чулуулгаар хучиж, хаягдлын нийт идэвхигүй ил гадаргыг багасгаж, салхинд элэгдэх эрсдлийг бууруулахын тулд гадаргууг нь ургамалжуулна.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Нөхөн сэргээлтийн бүртгэл тэмдэглэл

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

ID	Хэрэглээ/ Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцах талууд	Хяналтын хэлбэр
MW17	Гадаргын усны удирдлага	Хоосон чулуулгийн овоолго болон хаягдал хадгалах байгууламжаас гарах гадаргын ус ба аливаа шүүрэлтийг зохицуулахдаа ус хяналтгүй урсахаас урьдчилан сэргийлж, дахин ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор ус шүүрүүлэх болон шавхалтын хэд хэдэн арга хэмжээгээр зохицуулна.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг	Геотехникийн үзлэг шалгалт ХХБ дахь шүүрэлтийг хяналт шинжилгээний тайлан
MW18	Гадаргын усны удирдлага	Ил уурхай, далд уурхай, хоосон чулуулгийн овоолго, агуулах ба хаягдал хадгалах байгууламжаас гарах аливаа усыг технологийн усны хэлхээнд оруулах буюу бусад ашигтай аргаар ашиглах зорилгоор талбайд барьж байна.	Ил уурхайн хэлтсийн Уурхайн техникийн үйлчилгээний баг Ил уурхайн хэлтсийн Баяжуулалтын баг	Усны тэнцвэр

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

6. ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт шалгалт

Тус удирдлагын төлөвлөгөөг 2 жил тутам эсвэл үйл ажиллагаа болон байгаль орчны нөхцөлүүдтэй уялдан үүнээс бага давтамжтайгаар хянана.

Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлт оруулах шаардлага гарвал (“Оюутолгой”-н Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутгийн удирдлагын системд багтсан өөрчлөлтийн удирдлагын журам (ОТ-11-PRC-0001)-ын дагуу) тус удирдлагын төлөвлөгөөг шаардлага гарсан тухайн бүрт шинэчилж байна.

Энэхүү Удирдлагын төлөвлөгөөний хамгийн сүүлчийн шинэчлэгдсэн хувилбарыг “Оюу толгой”-н нийт ажилчдын хүртээл болгохын тулд ОТ портал дээр тавьж байна.

7. МОНИТОРИНГ

7.1 Хяналт шинжилгээнд тавигдах шаардлагын тойм

Ашиглалтын үе шатны үйл ажиллагаа төслийн стандартуудтай (4-р хэсэг: Төслийн стандартууд-ыг харна уу) нийцэж буйг шалгахын тулд хэрэгжүүлэх мониторингийн арга хэмжээг Эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац болон овоолгын удирдлагын төлөвлөгөө болон холбогдох журмуудад тусгасан.

Хэрэв мониторингийн явцад үйл ажиллагаа төслийн стандартуудад үл нийцсэн байдал тогтоогдвол магадлан шинжилж, зохих засаж залруулах арга хэмжээг авна (Энд харуулсан ОТ ЭМААБОАБОН-ийн МС-н 14-р элемент, Үл нийцэл, осол зөрчил, холбогдох арга хэмжээ хэсгийг харна уу).

7.2 Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд

Эрдсийн хаягдлын удирдлагын шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд ашиглах Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг (ГҮҮ) доор байгаа Хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд – Эрдсийн хаягдлын удирдлага

ID	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
MWM-KPI 01	Эрдсийн хаягдлын удирдлагын тайлагнасан зөрчлийн тоо	Зорилго: Зөрчлийг тэглэх. Тус төлөвлөгөөг хангаагүй зөрчлийн тоог бууруулж, үргэлжлүүлэн сайжруулах	Жилд тайлагнасан зөрчлийн тоо
MWM-KPI 02	Эрдсийн хаягдлын элэгдлийн давтамж	Мониторингийн дүнгээр элэгдэл буюу тунадасжилтын хяналтын арга хэмжээг зүй зохистойгоор хэрэгжүүлээгүй гэсэн зөрчил гараагүй.	Геотехникийн үзлэг шалгалтад тулгуурлан жилийн тунадасжилт, элэгдэл болон бүтэцтэй холбоотой тайлагнасан зөрчлийн тоо

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

ID	Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
MWM-KPI 03	Эрдсийн хаягдлын удирдлагатай холбоотой бохирдлын тохиолдлын тоо	Зорилго: Зөрчлийг тэглэх. Эрдэс хаягдал холбоотой хүлээж авсан гомдлын тоог бууруулж, үргэлжлүүлэн сайжруулах	Жилийн эрдсийн хаягдалтай холбоотой тайлагнасан олон нийтийн гомдлын тоо (Орон нутгийн хэлтэстэй холбоотой байна)

7.3 Хяналт шинжилгээний үндсэн үйл ажиллагаа

“Оюутолгой”-н эрдсийн хаягдлын мониторинг нь мониторингийн дараах гол үйл ажиллагаан дээр анхаарлаа хандуулдаг:

- Тохиолдож болзошгүй доголдлыг эрт таньж, түүнээс сэргийлэхийн тулд хаягдлын тогтвортой байдлын үзүүлэлтүүдэд мониторинг хийх.
- Хаягдлын шинж чанарыг загварчилж, болзошгүй бохирдлоос эрт сэргийлэхийн тулд хаягдлын агуулахын геохимийн шинж чанарт тогтмол мониторинг хийх.

Ашиглалтын шатанд хэрэгжүүлэх мониторингийн тусгай аргуудыг Хүснэгт 4-т үзүүлэв. Хэрэв аливаа мониторингийн дүн төслийн стандартуудыг хангахгүй байгаа нь илэрвэл, тэдгээрийг зөрчил гэж бүртгэн магадлан шинжилж, засаж залруулах арга хэмжээг авах болно (БОНМТ-ий баримт бичгээс дэлгэрэнгүй мэдээллийг харна уу).

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

Хүснэгт 4: Хяналт шинжилгээний гол арга хэмжээ

ID	Сэдэв/Хүрээ	Үзүүлэлтүүд	Аргачлал	Давтамж	Байршил	Тайлбар
MWM1	Эрдсийн хаягдлын бүртгэл	Эрдсийн хаягдлын жилийн хэмжээ болон нийт хэмжээ	Зайлуулж, боловсруулж, дахин ашиглах болон тусгай байгууламжуудад хадгалж байгаа бүх хаягдлуудыг байршил болон хүчил үүсгэх ба үл үүсгэх шинж чанараар нь бүртгэнэ	Улирал бүр	Бүх хаягдлын болон хөрсний овоолго, хаягдал хадгалах байгууламж	Ил уурхайн үйл ажиллагаа олон Гүний уурхайн техникийн үйлчилгээний багууд
MWM2	Геохими	Хүчиллэг чулуулгийн урсцын хязгаар	Хоосон чулуулаг болон баяжуулах үйлдвэрийн хаягдлаас ялгарах шүүрэлтийг эрт таньж, хүчиллэг чулуулгийн шүүрэлтийг зохицуулахын тулд мониторинг хийх	Шүүрэлт үүсэх бүр	Овоолго, хаягдал хадгалах байгууламж, карьер, бага агуулгатай хүдрийн овоолго	“Оюутолгой”-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын цогц төлөвлөгөөг харна уу
MWM3	Хаягдал хадгалах байгууламж	Геотехникийн тогтвортой байдал	Хаягдал хадгалах байгууламжийн далангийн хананы ажиглалт болон геотехникийн үнэлгээ	Өдөр тутмын хяналт шалгалт, долоо хоног тутмын тоног төхөөрөмжийн тайлан, улирал тутмын геотехникийн үнэлгээ	Далан ба хил хязгаар	Хаягдал хадгалах байгууламжийн барилга угсралт, ашиглалт, засвар үйлчилгээ, хяналт шинжилгээний гарын авлагыг үзнэ үү.
MWM4	Хаягдал хадгалах байгууламж	Гүний усны чанарын стандартууд	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс ХХБ-ийн гүний усны чанарт мониторинг хийж, шүүрэлтийн цөөрмийн ажиглалт хийнэ	ХХБ-ийн гүний ус, шүүрэлтийн байнгын хяналт шинжилгээний улирлын тайлан	ХХБ-ын хяналт шинжилгээний цооног/худаг ба шүүрэлт	Гүний усны мониторингийн төлөвлөгөөг харна уу
MWM5	Хоосон чулуулгийн овоолго	Гүний усны чанарын стандартууд	Ундай голын уст давхаргыг оруулан ХЧО, ХХБ-ийн эргэн тойронд усны чанарын мониторинг хийх	Гүний ус, шүүрэлтийн байнгын хяналт шинжилгээний жилийн тайлан	ХЧУ –ын хяналт шинжилгээний цооног/худаг болон шүүрэлт (тодорхойлсон бол)	Гүний усны мониторингийн төлөвлөгөөг харна уу

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е13-PLN-0001-Е	Хувилбар: 1.4

ID	Сэдэв/Хүрээ	Үзүүлэлтүүд	Аргачлал	Давтамж	Байршил	Тайлбар
MWM6	Тунадасжилт ба элэгдэл	Налуугийн тогтвортой байдал	Ил уурхай, ХЧО, ангилсан ислийн материалын тундасжилт, элэгдлийн нөлөөллүүд ба тогтвортой байдлыг ажиглаж үнэлгээ	Улирал тутмын геотехникийн хяналт шинжилгээ	Ил уурхай, ХЧО ба ангилагдсан исэлдсэн материал	Ил уурхайн үйл ажиллагааны уурхайн техникийн үйлчилгээний хэлтсийн геотехникийн баг

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е8-ПЛН-0001-М	Хувилбар: 1.1

8. СУРГАЛТ

8.1 Тойм

Бүх шаардлагатай сургалтыг танилцуулах сургалт (ерөнхий мэдлэг олгох) ба тухайн ажил үүрэгт шаардлагатай сургалт гэсэн хэлбэрээр зохион байгуулдаг.

8.2 Танилцуулах сургалт

“Оюутолгой”-н бүх ажилчид ба Оюутолгойд ажиллаж буй бүх гэрээт гүйцэтгэгчдийн ажилчдад танилцуулах ерөнхий сургалт, уурхайн талбайн зааварчилгаа ба эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулдаг.

8.3 Ажил үүрэгт хамааралтай сургалт

Эрдсийн хаягдал үүсгэдэг ажил үүрэг эрхэлдэг ажилчид ба гэрээт гүйцэтгэгчдэд “Оюутолгой”-н эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац ба овоолгын удирдлагын цогц төлөвлөгөөний тухай нэмэлт сургалт өгдөг.

Эрдсийн хаягдлыг тээвэрлэх ажилчдад нэмэлт сургалт өгөх ба тээвэрлэлт хийхдээ замдаа санамсаргүйгээр асгаралт үүсгэхээс урьдчилан сэргийлэх ёстой.

8.4 Сургалтын бусад шаардлагууд

Эрдсийн хаягдлын удирдлагатай холбоотой үйл ажиллагаанд оролцох үйлдвэрийн операторууд болон гол ажилчдад нэмэлт мэргэжлийн сургалтыг явуулах болно.

9. АУДИТ

9.1 Дотоод хяналт

Ажлын талбайн ахлах мэргэжилтэн, ахлах ажилтан нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутгийн өргөн сэдвээр тогтмол үзлэг шалгалтыг гүйцэтгэдэг.

Үзлэг шалгалтын үеэр илэрсэн аливаа осол, зөрчил нь Осол, зөрчлийн удирдлагын системд тайлагнагддаг (Элемент 14).

Аливаа үл нийцлийг Гүйцэтгэлийн үнэлгээ ба аудитын 16-р элементийн дагуу жилийн дотоод аудитын хөтөлбөрөөр хянан шинжилдэг. Ингэхдээ ЭМААБОАБОН-ийн удирдлагын системийн (БОННБҮ болон удирдлагын төлөвлөгөөг оруулаад) шаардлагуудад хир нийцэж байгааг үнэлэхийн тулд хийж гүйцэтгэгддэг.

Үзлэг, шалгалтын үеэр илэрсэн бүх осол зөрчил, үл нийцэл нь Байгаль орчин, нийгмийн Удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлогдсон Оюу толгойн ЭМААБОАБОН-ийн шаардлагуудын дагуу тайлагнагдаж байна.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е8-PLN-0001-М	Хувилбар: 1.1

9.2 Хөндлөнгийн аудит

Энэ төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэх нь Рио Тинтогийн ЭМААБО-ы Бизнесийн нийцлийн аудитын хөтөлбөр болон “Оюу толгой”-н зээлдэгчдийн үнэлгээний нэг хэсэг болдог.

9.3 Гүйцэтгэлийн тайлан

Аудит, үзлэг шалгалт болон осол зөрчлийн бүртгэл нь 8-р элемент-Баримт бичгийн хяналт болон 15-р элемент-Мэдээлэл, бүртгэлийн удирдлагын дагуу зохицуулагдана.

10. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ

Файлын нэр	ОТ-10-Е8-PLN-0001-М- Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө
Эхийг зохиогч	Химийн бодис ба хог хаягдлын удирдлагын баг
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Марк Слэйтер, ЭМААБО хэлтсийн Ерөнхий менежер
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	##

Эрсдэлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
<Дунд>	2013.09.01	Химийн бодис ба хог хаягдлын удирдлагын баг	2 жил тутам	2021.06.11

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	Химийн бодис ба хог хаягдлын удирдлагын баг	Марк Слэйтер, ЭМААБО хэлтсийн Ерөнхий менежер	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Марк Слэйтер, ЭМААБО хэлтсийн Ерөнхий менежер	Баримт бичгийн дугаарлалтыг засаж, баримт бичгийг хянав.
1.2	2015.06.01	Марк Ньюби, Раби Синг Махоний Д.Алтерио	ЭМААБОАБОН-ийн Ерөнхий менежер	Өөрчлөлт оруулсан тэмдэглэл 2015-003 Албан тушаал, үүрэг хариуцлагыг шинэчилсэн, ӨУ-аас баталсан зээлдүүлэгчийн MW05

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E8-PLN-0001-M	Хувилбар: 1.1

				болон MW06 үүрэг амлалтыг оруулсан, хяналт шинжилгээний давтамжийг шинэчилсэн (MWM3, 4, 5, 6). Өөрчлөлт оруулсан тэмдэглэл 2014-3 1-р Босоо амны хоосон чулуулгийн овоолгыг шилжүүлэн байрлуулсан тухай шинэчилсэн мэдээлэл, 2014-3 сар далд уурхайн хоосон чулуулгийн овоолгыг шилжүүлэн байрлуулсан тухайн шинэчилсэн мэдээлэл
1.3	2017.11.28	Буянтогтохын Ууганбаяр	Нарангийн Эрдэнэбаяр	Тус төлөвлөгөөг Байгаль орчны шинэ стандартын дагуу хянан засварлав. НОС 2019-008
1.4	2019.06.11	Марк Ньюби, Тогтохбаярын Отгонбаяр, Нарангийн Эрдэнэбаяр, Сэржхүмбийн Амар- Амгалан, Буянтогтохын Ууганбаяр	ЭМААБОАБОН-ийн Ерөнхий менежер Марри Сварипа	Байгаль орчны лавлагаа стандартуудыг шинэчлэв; Хэлтсүүдийн нэрийг шинэчлэв; Магадлан баталгаажуулах арга хэрэгсэл хийгээд хариуцагч талуудын талаарх мэдээллийг сайжруулав. Эрдсийн хаягдал, хүчиллэг чулуулгийн урсац болон хаягдлын цэгийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнөөс зарим хэсгийг нэмэв.